

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Дадал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/117/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Audit.mn

Хэнтий аймаг

Чингис хот

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 мэйл хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 мэйл хаяг: Oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Энх-Амгалан
Утас: 91119424 мэйл хаяг: Enkh-Amgalang@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Төлбөрийн акт.....	9
3.2 Албан шаардлага	9
3.3 Зөвлөмж	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.25 № 291

танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.ДАМДИНПҮРЭВ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Дадал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн түүвэр тооллогоор 2023 онд ашиглалтад авсан 6,800.0 мянган төгрөгийн 2 тавилга дутагдсан;
- Нэр бүхий 24 ажилтанд 8,062.9 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг үндэслэлгүй олгосон;
- Сургалтын төлбөрт шилжүүлсэн 5,985.0 мянган төгрөг нь сургалт зохион байгуулсан тухай нотлох баримт хангалтгүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зэрэг зөрчлүүд нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 4-т "Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачлагчаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно", нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-д "Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д

232520291

"Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, толилуулга, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Хүүхдийн хоолны 187,243.6 мянган төгрөгийн материалыг тендер зарлалгүй шууд худалдан авалт хийсэн байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар 208,091.5 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс 14,862.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 193,228.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг төлөвлөж, 90 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	255,568,863.00	584,450,260.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	78,481,817.87	407,081,084.17
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	78,481,817.87	407,081,084.17
3121	Төгрөг	78,481,817.87	407,081,084.17
31211	Төрийн сангийн харилцах	78,481,817.87	407,081,084.17
33	АВЛАГА	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	177,087,045.13	177,369,176.33
351	Түүхий эд материал	-	-
354	Хангамжийн материал	177,087,045.13	177,369,176.33
35410	Бичиг хэргийн материал	1,301,830.00	6,173,330.00
35420	Аж ахуйн материал	124,698,803.28	121,217,515.16
35460	Хүнсний материал	31,918,676.00	22,938,472.28
35470	Бусад хангамжийн материал	19,167,735.85	27,039,858.89
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,426,169,659.96	3,404,300,845.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,426,169,659.96	3,404,300,845.70
392	Биет хөрөнгө	2,361,617,659.96	3,339,120,845.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,277,525,140.00	3,359,865,269.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(337,214,634.60)	(417,113,549.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,600,000.00	10,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,179,999.88)	(4,239,999.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	486,164,453.85	550,631,143.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	(146,185,152.42)	(228,737,929.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	140,102,171.37	141,670,171.37
39208	Хуримтлагдсан элэгдэл	(67,773,318.36)	(87,835,010.61)
39217	Ном	1,579,000.00	14,280,750.00
393	Биет бус хөрөнгө	64,552,000.00	65,180,000.00
39301	Програм хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(250,000.00)	(250,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	64,552,000.00	65,180,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,681,738,522.96	3,988,751,106.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	140,232,187.00	90,477,900.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	140,232,187.00	90,477,900.00
413	Өглөг	140,232,187.00	90,477,900.00
4136	Бусад өглөг	140,232,187.00	90,477,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	140,232,187.00	90,477,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,541,506,335.96	3,898,273,206.20
51	Засгийн газрын хувь оролцоо	2,541,506,335.96	3,898,273,206.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	869,671,663.96	869,671,663.96
512	Хуримтлагдсан үр дүн	1,663,090,648.44	3,019,857,518.68
51210	Өмнөх үеийн үр дүн	1,663,090,648.44	1,663,090,648.44
51220	Тайланг үеийн үр дүн	-	1,356,766,870.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,744,023.56	8,744,023.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,681,738,522.96	3,988,751,106.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,816,053,954.97	3,820,971,523.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	129,077,654.97	1,154,866,223.68
120	Нийтлэг татварын бус орлого	129,077,654.97	1,154,866,223.68
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	129,077,654.97	1,154,866,223.68
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,530,900.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,891,500.00	3,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	110,655,254.97	1,151,866,223.68
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,686,976,300.00	2,666,105,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,522,539,000.00	2,363,310,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,522,539,000.00	2,363,310,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	164,437,300.00	302,795,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	164,437,300.00	302,795,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,727,495,934.92	2,458,764,653.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,727,495,934.92	2,458,764,653.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,665,786,749.92	2,325,941,354.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,087,504,349.08	1,528,798,731.90
210101	Үндсэн цалин	618,954,829.58	951,538,221.90
210102	Нэмэгдэл	430,562,227.05	528,164,493.00
210104	Урамшуулал	37,987,292.45	49,096,017.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,864,099.05	194,209,344.98
210201	Тэтгэврийн даатгал	95,059,224.31	132,948,899.94
210202	Тэтгэмжийн даатгал	11,091,265.21	16,034,826.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,970,499.40	7,991,005.13
210204	Ажилгүйдлийн даатгал	2,299,651.98	7,445,336.44
210205	Эрүүл мэндийн даатгал	24,443,458.15	29,789,276.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,247,886.00	226,429,909.68
210301	Гэрэл, цахилгаан	18,737,604.00	17,808,797.10
210302	Түлш, халаалт	142,670,282.00	198,475,699.88
210303	Цэвэр, бохир ус	840,000.00	10,145,412.70
2104	Хангамж, бараа материалын зардал	4,164,219.00	-
210401	Бичиг хэрэг	349,439.00	-
210402	Тээвэр, шатахуун	3,734,780.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	80,000.00	-
2105	Нормативт зардал	89,269,582.00	93,945,299.72
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	164,800.00	-
210502	Хоол, хүнс	89,104,782.00	93,945,299.72
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,499,800.00	9,480,375.00
210604	Урсгал засвар	3,499,800.00	9,480,375.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,678,300.00	23,628,282.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,875,900.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,802,400.00	23,628,282.82
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	155,558,514.79	249,449,409.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,127,925.25	79,338,680.08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,510,301.00	9,531,765.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	120,920,288.54	160,578,964.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,709,185.00	132,823,299.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,709,185.00	66,545,684.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	61,709,185.00	66,545,684.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, са	00.00	66,277,615.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	66,277,615.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	88,558,020.05	1,362,206,870.28
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	5,440,000.04
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	5,440,000.04
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-5,440,000.04
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	88,558,020.05	1,356,766,870.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,705,398,700.00	2,669,105,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,422,400.00	3,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	18,422,400.00	3,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,422,400.00	3,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,530,900.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,891,500.00	3,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,686,976,300.00	2,666,105,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,522,539,000.00	2,363,310,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,522,539,000.00	2,363,310,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	164,437,300.00	302,795,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллагаас/	164,437,300.00	302,795,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,641,448,791.73	2,321,899,033.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,641,448,791.73	2,321,899,033.70
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,573,035,557.73	2,180,105,868.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,087,038,665.48	1,543,465,316.00
210101	Үндсэн цалин	618,489,145.98	969,866,935.00
210102	Нэмэгдэл	430,562,227.05	518,707,820.00
210104	Урамшуулал	37,987,292.45	54,890,561.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,229,782.65	179,542,760.88
210201	Тэтгэврийн даатгал	95,524,907.91	120,198,769.38
210202	Тэтгэмжийн даатгал	11,091,265.21	15,687,008.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,970,499.40	7,982,306.26
210204	Ажилгүйдлийн даатгал	2,299,651.98	7,548,136.80
210205	Эрүүл мэндийн даатгал	21,343,458.15	28,126,540.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	161,437,300.00	226,429,909.68
210301	Гэрэл, цахилгаан	18,447,400.00	17,808,797.10
210302	Түлш, халаалт	142,149,900.00	198,475,699.88
210303	Цэвэр, бохир ус	840,000.00	10,145,412.70
2105	Нормативт зардал	107,871,009.00	75,995,230.00
210502	Хоол, хүнс	107,871,009.00	75,995,230.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	9,639,675.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	9,639,675.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамт	21,398,300.00	24,141,282.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	11,875,900.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,522,400.00	24,141,282.82
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,060,500.60	120,891,694.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,173,800.60	104,589,029.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,886,700.00	16,302,665.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,413,234.00	141,793,165.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,413,234.00	75,515,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	68,413,234.00	75,515,550.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	66,277,615.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	66,277,615.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	63,949,908.27	347,206,266.30
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	41,031,813.00	18,607,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	41,031,813.00	18,607,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	41,031,813.00	18,607,000.00
223001	Бусад хөрөнгө	41,031,813.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	18,607,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(41,031,813.00)	(18,607,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	22,918,095.27	328,599,266.30
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	78,481,817.87
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	407,081,084.17

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	869,671,663.96	8,744,023.56	1,663,090,648.44	2,541,506,335.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	869,671,663.96	8,744,023.56	1,663,090,648.44	2,541,506,335.96
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			-	-
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	869,671,663.96	8,744,023.56	1,663,090,648.44	2,541,506,335.96
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	869,671,663.96	8,744,023.56	1,663,090,648.44	2,541,506,335.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	869,671,663.96	8,744,023.56	1,663,090,648.44	2,541,506,335.96
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
Тайлант үеийн үр дүн			1,356,766,870.24	1,356,766,870.24
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	869,671,663.96	8,744,023.56	3,019,857,518.68	3,898,273,206.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-
2	НИЙТ ЗАРЛАГА БАЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,747,560,000.00	2,274,228,418.38	473,331,581.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,747,560,000.00	2,274,228,418.38	473,331,581.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,669,759,300.00	2,198,712,868.38	471,046,431.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,832,203,500.00	1,543,465,316.00	288,738,184.00
210101	Үндсэн цалин	1,171,804,900.00	969,866,935.00	201,937,965.00
210102	Нэмэгдэл	627,153,300.00	518,707,820.00	108,445,480.00
210104	Урамшуулал	33,245,300.00	54,890,561.00	-21,645,261.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шилжүүлэг	229,025,500.00	179,542,760.88	49,482,739.12
210201	Тэтгэврийн даатгал	155,737,300.00	120,198,769.38	35,538,530.62
210202	Тэтгэмжийн даатгал	18,322,100.00	15,687,008.32	2,635,091.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,161,000.00	7,982,306.26	1,178,693.74
210204	Ажилгүйдлийн даатгал	9,161,000.00	7,548,136.80	1,612,863.20
210205	Эрүүл мэндийн даатгал	36,644,100.00	28,126,540.12	8,517,559.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	292,707,500.00	226,429,909.68	66,277,590.32
210301	Гэрэл, цахилгаан	25,111,400.00	17,808,797.10	7,302,602.90
210302	Түлш, халаалт	255,683,800.00	198,475,699.88	57,208,100.12
210303	Цэвэр, бохир ус	11,912,300.00	10,145,412.70	1,766,887.30
2105	Норматив зардал	136,898,200.00	75,995,230.00	60,902,970.00
210502	Хоол, хүнс	136,898,200.00	75,995,230.00	60,902,970.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,087,700.00	12,087,675.00	25.00
210604	Урсгал засвар	12,087,700.00	12,087,675.00	25.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэр	39,191,200.00	35,390,282.82	3,800,917.18
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	39,191,200.00	35,390,282.82	3,800,917.18
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	127,645,700.00	125,801,694.00	1,844,006.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,343,000.00	109,499,029.00	1,843,971.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,302,700.00	16,302,665.00	35.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,800,700.00	75,515,550.00	2,285,150.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	77,800,700.00	75,515,550.00	2,285,150.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	77,800,700.00	75,515,550.00	2,285,150.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,747,560,000.00	2,602,827,684.68	144,732,315.32
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,363,310,100.00	2,363,310,100.00	0.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,363,310,100.00	2,363,310,100.00	0.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	302,795,200.00	236,517,584.68	66,277,615.32
132001	Орон нутгийн төсвөөс	302,795,200.00	236,517,584.68	66,277,615.32
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	81,454,700.00	3,000,000.00	78,454,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	3,000,000.00	0.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	78,454,700.00		78,454,700.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		78,481,817.87	-78,481,817.87
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		407,081,084.17	-407,081,084.17
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00
62	АЖИЛЛАГААНЫ ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	60.00	59.00	1.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	43.00	40.00	3.00
620003	Үйлчлэх ажилтан	16.00	18.00	-2.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	60	59	1
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮЕ)	40.00	38.00	2.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч	01.00	01.00	0.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13	15	(2)
650010	Гэрээт ажилтан	6.00	5.00	1.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд алдаа¹ илрээгүй.

Аудитаар 208,091.5 мянган төгрөгийн зөрчил² илэрч 1 зөвлөмж, 2 төлбөрийн акт, 2 албан шаардлага хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

Үндсэн хөрөнгийн түүвэр тооллогоор 2023 онд ашиглалтад авсан 6,800.0 мянган төгрөгийн 2 тавилга дутагдсан.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Нэр бүхий 24 ажилтанд 8,062.9 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг үндэслэлгүй олсон байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Сургалтын төлбөрт шилжүүлсэн 5,985.0 мянган төгрөг нь сургалт зохион байгуулсан тухай нотлох баримт хангалтгүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Дотуур байрны хүнс, сурагчийн үдийн хоолны багцыг тендер зарлалгүй шууд худалдан авалт хийсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Байгууллагын дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн үлдэх өртөггүй 403 ширхэг хөрөнгийг зохих журмын дагуу шийдвэрлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үлдэх өртөггүй данс бүртгэлд байгаа хөрөнгийг зохих хууль, журмын дагуу шийдвэрлэх арга хэмжээ авч хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлэх бөгөөд ирүүлээгүй тохиолдолд тус хуулийн 42.2-т заасныг үндэслэн ажлаас халах, сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохыг анхааруулж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үндэслэлгүй илүү цагийн хөлс олгосон	1	8,062.9	1	8,062.9								
Хөрөнгө дутагдуулсан	1	6,800.0	1	6,800.0								
Нотлох баримт хангалтгүй хөрөнгө зарцуулсан	1	5,985.0			1	5,985.0						
Үлдэх өртөггүй хөрөнгийг зохих журмын дагуу шийдвэрлээгүй	1	0					1	0				
Дүн	4	20,847.9	1	14,862.9	1	5,985.0	1	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тендер зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн	1	187,243.6			1	187,243.6		-
Дүн	1	187,243.6			1	187,243.6		-
Нийт дүн	1	187,243.6			1	187,243.6		-



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 107-ХЭА-2025/117/НА-СТА-ТШЗ
A2360453 Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий 24 ажилтанд үндэслэлгүйгээр 8,062.9 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 4-т "Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачлагчаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно", нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8. "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндэслэлгүй олгосон 8,062.9 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг захирал Д.Дамдинпүрэв, нягтлан бодогч Э.Дэнсмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Г.ЭНХ-АМГАЛАН

232505107



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 23

Дугаар 128-ХЭА-2025/117/НА-СТА-ТШЗ
А 2360453

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүүхдийн хоолны 187,243.6 мянган төгрөгийн материал худалдан авахад цахим тендер зарлаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагаа зохион байгуулдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг захирал Д.Дамдинпүрэв, нягтлан бодогч Э.Дэнсмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Г.ЭНХ-АМГАЛАН



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 23

Дугаар 127-ХЭА-2025/117/НА-СТА-ТШЗ
А 2360453 Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн бус болон сургалтын байгууллагуудад 5,985.0 мянган төгрөгийн сургалтын төлбөрийг шилжүүлсэн боловч сургалт зохион байгуулсан тухай холбогдох баримт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг захирал Д.Дамдинпүрэв, нягтлан бодогч Э.Дэнсмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Г.ЭНХ-АМГАЛАН



232504127



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 108-ХЭА-2025/117/НА-СТА-ТШЗ
А2360453 Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны үндсэн хөрөнгийн үлдэгдлийг түүвэрлэн тооллого хийж баталгаажуулахад 6,800.0 мянган төгрөгийн тавилга дутагдсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-д "Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.7 -д "Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Дутагдсан хөрөнгийн үнэ 6,800.0 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг захирал Д.Дамдинпүрэв, нягтлан бодогч Э.Дэнсмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Г.ЭНХ-АМГАЛАН

232505108